



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: [www.ulaanbaatar.mn](#)

2024-05-16 № 03/2915

танай _____ -ны № _____ -т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамж (Улаанбаатар хот)” НЗДТГ/20240102009 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой “Арш Технологи” ХХК-иас 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.


1. Генераторуудын суурилуулах байрлал нь байшингийн дээвэр эсвэл гадаа байрлах уу? Генератор суулгах байршууд нь хэр хол гэж тооцоолох вэ? Түүнээс хамаарч материалын тооцоолол өөрчлөгдөх эрсдэлтэй байгаа юм.

Хариулт: Генераторуудыг байшингийн гадна байрлуулах ба барилгаас 1-5 метрийн зайд байхаар тооцож үнийн санал ирүүлнэ.

2. Байрнуудын заслын талаарх ажлын даалгаврыг хаанаас тодруулах вэ? Яг ямар хэмжээний заслын ажил төлөвлөсөн бэ? Хана тааз гэх мэт дэлгэрэнгүй ажлын даалгавар өгөх боломжтой юу?

Хариулт: Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын дэргэд байгуулах “Теле камерын хяналтын дэд төв”-ийн байрны зохион байгуулалт (одоо байгаа), байршил, барилгын хийц нь харилцан адилгүй бөгөөд ханан дэлгэц бүхий хяналтын өрөө, тоног төхөөрөмж байрлуулах серверийн өрөөг ижил загвараар бүрэн засварлана. Ханан дэлгэц бүхий хяналтын өрөөний хэмжээ ойролцоогоор 10x13 метр, тоног төхөөрөмж байрлуулах серверийн өрөө нь бхб метрийн хэмжээтэй байна. Хана нураах, өрөх, хаалга суурилуулах ажил гарна. Шаардлагатай бол бусад өрөөнүүдэд өнгө засвар хийж болно. “Теле камерын хяналтын дэд төв”-ийн байр тодорхой болсон тул шаардлагатай бол газар дээр нь очиж үзэх боломжтой болно.

ДАРГА



Л.ХОСБАЯР

1110202739